



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/08

Амардалай

Биеийн тамир спортын орон тооны бус
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.2, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын биеийн тамир спортын орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)
Нарийн бичиг: Ц.Билэг-Ариун (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд: А.Цэрэндэжид (Сургуулийн Биеийн тамирын багш)
Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)
Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)
Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)
О.Улаанхүү (Ахмадын төлөөлөл)
Н.Базаррагчаа (ЭМТ-ийн сувилагч)
Г.Батцоож (Төрийн банкны теллер)
У.Үржинханд (Архив бичиг хэргийн ажилтан)
Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын нягтлан бодогч)

2. Орон нутгийн хэмжээнд биеийн тамир спортын үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжүүлэх, иргэд олон нийтийн оролцоог хангаж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тухайн жилийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын зөвлөлийн дарга (Л.Золжаргал)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн А/11 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

122/01011